Батлав: БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны бодлого
зохицуулалтын газрын дарга /Г. ЭНХМӨНХ/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: “ХОС ХАС ”
ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Б.ДӨЛГӨӨН/

БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ “ӨГӨӨМӨР ” АЛТНЫ ШОРООН ОРД АШИГЛАХ" ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:
MV-008866, MV-001329

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2100231

ХЯНАСАН: БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН
МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН: “ХОС ХАС” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН /Х. Буманцэцэг/

Гарчиг

1. **Оршил** ... 3
2. **ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА** ... 4
2.1. Төслийн байршил ... 4
1.2 Ус хангамж: ... 7
1.3. Цахилгаан хангамж ... 8
1.4. Хүчин чадал, техник технологи ... 8
1.5. Уул технологийн хэсэг ... 9
3. **БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ СУДАЛГАА** ... 12
4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛ ... 16
4.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл ... 16
4.2 Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл ... 16
4.3Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл ... 16
4.4 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ... 16
4.5 Газрын гадарга хэвлий түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл ... 16
5. **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ** ... **17**
5.1 Байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй ... 18
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ... 20
7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ... 23
8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ... 24
9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ... 25
10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ... 25
11. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ... 26
12. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ... 27
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ... 29
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ ... 30
15. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ... 31
16. ДҮГНЭЛТ ... 33
17. АШИГЛАСАН МАТЕРИАЛ ... 34
18. ХАВСРАЛТ ... 35

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт1. ***MV-008866 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгийн солбицол***

Хүснэгт 2.. ***“Хос Хас” ХХК-ний эзэмшлийн техник тоног төхөөрөмжүүд***

Хүснэгт-3 ***Бүрэхангай сумын темпратурын үзүүлэлт***

Хүснэгт.4 ***Бүрэхангай сумын салхины үзүүлэлт***

Хүснэгт.5 ***Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа***

Хүснэгт 6. ***2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал*** **Хүснэгт .7** ***Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*** **Хүснэгт 8**. ***Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө зардал, аргачлал***

Хүснэгт.9 ***Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө***

Хүснэгт 10. ***Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө***

Хүснэгт.11 ***Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө***

Хүснэгт 12. ***Байгаль орчны менежментийн төлөвлөгөө***

Хүснэгт-13 ***БОМТ-г хэрэгжилтийг тайлагнах хуваарь***

Хүснэгт 14. ***Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөр шинжилгээ хийх төсөв төлөвлөлт***

1. Оршил

“Хос Хас” ХХК-ийн Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Өгөөмөрийн алтны шороон ордыг эзэмшин ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус ордод MV-008866, MV-001329, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайнууд хамрагддаг болно. Тус талбайд 2013 оноос эхлэн үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагаа явуулахдаа ул оронд мөрдөгдөж буй хууль дүрэм журмын хүрээнд тайлан төлөвлөгөөг хуулийн хугацаанд гарган ажилласан.

Төлөвлөгөөт онд Өгөөмөрийн алтны шороон ордын MV-008866 тусгай зөвшөөрлийн талбайн Өгөөмөр-4 хэсэглэлд олборлолтын ажлыг 12 дүгээр сарын 15 дуустал хийж гүйцэтгэнэ. Энэ хугацаанд нийт 11014.28мян.м3 хөрс хуулж дундажаар 636мг.м3 агуулга бүхий 364.02 мян.м3 элс олборлон баяжуулж ажиллахаар төлөвлөв.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр	**“Өгөөмөр”** алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага: ***БОННҮ хийсэн ААН-ийн нэр***	**“Хос Хас ” ХХК** Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:9011064046 Регистрийн дугаар: **2100231** Бүртгүүлсэн огноо: 2006.12.26 Хаяг: УБ хот, БГДүүрэг, 29-р хороо, Эрчим хүчний гудамж 32-р барилга Утас: 99239111,99312173 Тус төслийн ТЭЗҮ нэмэлтээр “Баян Овоот Майнинг” ХХК /2025он/ БОННҮ-г “Монслов ”ХХК хийж гүйцэтгэсэн. /2025 он/

2.1. Ордын байршил

Өгөөмөрийн алтны шороон орд нь Улаанбаатар хотоос 297 км-т, Дархан хотоос 185 км-т, Эрдэнэт хотоос 180 км-т, Булган аймгийн төвөөс 130 км-т, Бүрэгхангай сумын төвөөс 77 км-т, Хайлаастын алтны уурхайгаас 48 км-т тус тус оршино.

Монгол улсын М1:100’000 масштабтай байр зүйн зургийн М-48-125, М-48-126 дугаартай хавтгайнуудын заагт байрлана. Уг орд байрлаж буй нийт талбайн булангийн цэгүүдийн газар зүйн солбицлыг дараах хүснэгтүүдэд харууллаа.

Хүснэгт № 1. MV-008866 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгийн солбицол

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	104° 31' 14.48"	48° 25' 9.47"	29	104° 28' 37.95"	48° 23' 6.81"
2	104° 31' 24.2"	48° 25' 9.52"	30	104° 28' 30.95"	48° 23' 6.81"
3	104° 31' 23.94"	48° 25' 38.64"	31	104° 28' 30.95"	48° 22' 51.82"
4	104° 31' 38.53"	48° 25' 38.7"	32	104° 28' 57.95"	48° 22' 51.82"
5	104° 31' 38.4"	48° 25' 51.65"	33	104° 28' 57.95"	48° 23' 15.31"
6	104° 31' 14.03"	48° 25' 51.7"	34	104° 29' 24.45"	48° 23' 15.31"
7	104° 31' 14.03"	48° 25' 34.82"	35	104° 29' 24.45"	48° 23' 8.82"
8	104° 31' 6.02"	48° 25' 34.84"	36	104° 29' 35.95"	48° 23' 8.82"
9	104° 31' 6.02"	48° 25' 25.83"	37	104° 29' 35.95"	48° 23' 51.8"
10	104° 30' 37.03"	48° 25' 25.84"	38	104° 30' 1.02"	48° 23' 51.83"
11	104° 30' 37.03"	48° 25' 15.83"	39	104° 30' 1.02"	48° 24' 11.84"
12	104° 30' 1.02"	48° 25' 15.83"	40	104° 29' 51.95"	48° 24' 11.81"
13	104° 30' 1.02"	48° 25' 9.83"	41	104° 29' 51.95"	48° 24' 3.8"
14	104° 29' 43.95"	48° 25' 9.8"	42	104° 29' 27.95"	48° 24' 3.8"
15	104° 29' 43.95"	48° 24' 58.8"	43	104° 29' 27.95"	48° 24' 21.81"
16	104° 29' 32.95"	48° 24' 58.8"	44	104° 29' 33.95"	48° 24' 21.81"
17	104° 29' 32.95"	48° 24' 51.8"	45	104° 29' 33.95"	48° 24' 29.8"
18	104° 29' 23.95"	48° 24' 51.8"	46	104° 29' 42.95"	48° 24' 29.8"
19	104° 29' 23.95"	48° 24' 44.81"	47	104° 29' 42.95"	48° 24' 41.8"
20	104° 29' 16.95"	48° 24' 44.81"	48	104° 30' 1.02"	48° 24' 41.83"
21	104° 29' 16.95"	48° 24' 36.8"	49	104° 30' 1.02"	48° 24' 16.83"
22	104° 29' 8.95"	48° 24' 36.8"	50	104° 30' 41.01"	48° 24' 16.83"
23	104° 29' 8.95"	48° 24' 29.8"	51	104° 30' 41.01"	48° 24' 14.3"
24	104° 29' 4.95"	48° 24' 29.8"	52	104° 30' 55.54"	48° 24' 14.35"
25	104° 29' 4.95"	48° 24' 24.8"	53	104° 30' 55.43"	48° 24' 25.68"
26	104° 28' 57.95"	48° 24' 24.8"	54	104° 31' 5.17"	48° 24' 25.72"
27	104° 28' 57.95"	48° 23' 24.81"	55	104° 31' 5.03"	48° 24' 40.29"
28	104° 28' 37.95"	48° 23' 24.81"	56	104° 31' 14.75"	48° 24' 40.33"



Зураг -1. Төслийн талбайн байршил

1.2 Ус хангамж:

Өгөөмрийн ордын хэмжээнд гүйцэтгэсэн геологийн болон гидрогеологийн ажлын мэдээллийг боловсруулан ордын геологийн нөхцөлийг тодорхойлж, ил аргаар олборлоход ил уурхайд урсан орох газрын доорх усны шүүрэлтийн хэмжээг 19.74 м3/цаг болохыг тооцов.

Унд ахуйн усны хэрэгцээг өөрийн гүний өрөмдмөл худгаас хангана. Ундарга нь 1л/с ба усны химийн найрлага нь гидрокарбонат кальцийн, эрдэсжилт 0.4 г/л-ээс хэтрэхгүй. Химийн найрлагаараа унд ахуйн хэрэглээний усны MNS 900:2005 стандартыг баримтлан, усыг хэмнэлттэй зарцуулахын тулд усан хангамжийг битүү циклээр буюу усан сан байгуулан ажиллана. Усан сангийн нийт багтаамж 200мян.м3 бөгөөд ууршилт, хөрсөн дэх шингэлтээс үүсэх усны алдагдал нь хөрснөөс нэвчин ирэх усаар нөхөн сэлбэгдэж байна. Усны хэрэглээний эргэлтийн усны хэмжээг 75хувиас бууруулахгүй байх зорилт тавин ажиллана.

Зураг 2. *Худгийн барилга,*

1.3. Цахилгаан хангамж:

Төв аймгийн Заамар сумын нутагт байрлаж буй 2*10000кВА чадалтай 110/3 5/6кВ-ын Баясаглант дэд станцаас Өгөөмарийн алтны уурхайд хагийн ойр 17км-т орших дэд станц нь юм. Иймд уурхайг эрчим хүчний эх шшсвэртэй холбох зорилгоор Баясаглант дэ станцаас Заамар сумын Өгөөмөр тосгоныг холбосон сүлжээнээс 35кВ-ийн өндөр хүчдэлийн шугамыг шинээр татан, улсын эрчим хүчний системд холбогдсон . Уурхайд 44кВт чадалтай 8гееп -80м3 маркийн элс угаах төхөөрөмж 2ш, 25кВт чадалтай шахах Д-280/75 носас-+2, Д-320/90 маркийн ус татах 2 ширхэг носас, 18кВт чадалтай Р1-110РЕ маркийн гүний худгийн носас , уурхайн гэрэлтүүлэг, засварын цех, граш, үйлдвэрийн талбай, уурхайн захиргаа, ажилчидын байр зэрэг цахилгаан хэрэглэгчид нь 0,4кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангагдсан болно.

1.4. Хүчин чадал, техник технологи

Алт агуулсан элсийг угаан баяжуулах технологийн үзүүлэлт, тус ордод хийсэн лабораторийн шинжилгээний үр дүн /алтны 57,03% нь -0,63 мм-+0,16 мм/ зэргийг харгалзан эргэлтэт скруббер ба шлюзийн хослол бүхий баяжуулах төхөөрөмжөөр ялган авдаг. Алттай давхаргаас олборлосон элсийг угаах төхөөрөмжинд усан буугаар буудаж хийхэд хүлээн авах торон дээр +100 мм-ийн том чулуунууд ялгаран хаягдаж, -100 мм нь

эргэлтийн шигшүүрт угаагдан +20 мм, -20 мм-ийн хэмжээтэй ангилагдана. -20 мм нь ахин ангилагдаж +5 мм, -5 мм хэмжээтэй ангилагдана. Угаагдаж байгаа элсний +20 мм, +5 мм-ийн хэмжээтэй нь хуурай хаягдалд овоологдон бульдозероор түрэгдэн овоологдох ба -5 мм хүртлэх мөхлөгүүд нь шлюзэд тунан угаагддаг.

Баяжуулж байгаа технологи нь элсний ашигт эрдсийг аль болох өндөр хувиар ялган авах зорилготой бөгөөд үйлдвэрээс гарч байгаа технологийн хаягдал нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байхаар шийдэгдсэн байна.

1.5. Уул технологийн хэсэг

Хос Хас ХХК нь комацу PC-1250, PC-600-2ш Doosan-500-2ш HD465, Норд , Тонли маркийн автосамосвал, ковш зэрэг техник тоног төхөөрөмжийг ашиглан хийж гүйцэтгэдэг . Комацу ,Doosan экскаваторын тусламжтай ухаж шидэх , шилжүүлэн зөөх болон ТОНЛИ маркийн автосамосвалын хослолоор тээвэртэй ашиглалтын системээр ил аргаар ашигласан ба хөрсний овоолгыг нөхөн дүүргэх ажил гүйцэтгэнэ.

Хүснэгт 2*.“Хос Хас” ХХК-ний эзэмшлийн техник тоног төхөөрөмжүүд*

Тоног Төхөөрөмжийн зориулалт	**Тоног төхөөрөмжийн нэр төрөл**	**Үйлдвэр-лэсэн улс**	**Тоон үзүүлэлт, хэмжих нэгж**	**Тоо, ширхэг**
Хөрс хуулалтанд ашиглах 	Экскаватор КОМАТЦУ PC1250	Япон	6.7 м^3	6

Хөрс хуулалтанд ашиглах 	Экскаватор DOOSAN PC500	БНСУ	6.7 м^3	2
Элс олборлолтонд ашиглах 	*комлтзи PC600*	Япон	3.2 м^3	1
Уурхайн хөрс тээвэрлэлтэнд 	КОМАТЦУ HD465	Япон	55 тн	4
Элс тээвэрлэлтэнд 	TONLY TL855 марк	БНХАУ	50 тн	21

	КОМАТЦУ D275	Япон	7.6 м^3	2
	КОМАТЦУ WA380	ЯПОН	3.0 м^3	2
Ее оодоаеа шиеаг ааеаооеаоад	*КОМАТЦУ D65E*	Япон	5.6 м^3	1
Скрубберээр баяжуулах технологи				
	Угаах төхөөрөмж СБ- 80 марк-н	ОХУ	80 м^3/цаг	2
	Д200-36 маркийн насос	БНХАУ	320 м^3/цаг	

	СКО-2 маркийн сэгсрэх ширээ	БНХАУ	1.2т/цаг	

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ СУДАЛГАА

Төслийн талбай нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт Орхон Туулын бэлчирт , Туул голын доод хэсэгт оршино. Туул голын сав газар нь далайн түвшинээс харьцангуй өндөр өргөгдсөн , далай тэнгисийн алслагдсан , эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн тул өдөр шөнийн агаарын темпратурын ялгаа их хүйтэний улирал харьцангуй урт харин зун богино хур тундасны ихэнхи хувь нь дулааны улиралд орох бөгөөд ихэвчлэн агаарын тогтворгүйцилээс үүдэн конвекцийн гаралтай байдаг. Эх газрын эрс тэс уур амьсгалтай , хамгийн хүйтжн сар нь 1-р сард -37°C-40°C , хамгийн дулаан сар нь 7-р сард агаарын темпратур +32°C хүрдэг .

Хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангай их мужийн Хар хүрэн , хүрэн хөрсний дэд бүсийн Орхон-Шаамарын хөрсний тойрогт тус тус хамрагдаж байна. Тусгай зөвшөөрөлтэй талбайнуудаар Хөнгөн шавранцар доор карбонаттай Хар хүрэн , Сайргархаг, карбонаттай хөнгөн шавранцар Хар хүрэн хөрс, хөнгөн шавранцар хүрэн хөрс зэрэг 3 хэв төрлийн хөрс тархсан байна.

Ургамал-Газарзүйн мужлалын хувьд Евроазийн шилмүүст ой, нуга хээрийн их муж чийглэгдүү нхэв шинжийн Дорнрд азийн муж Орхон-Туулын нам уулын тойрогт хамаарагдана. /Монгол улсын үндэсний атлас 2009 он/ . Монгол орны Физик- Газарзүйн мужлалаар Хангайн уулт их муж, Орхон Туулын сав бэсрэг уулсын муж Орхон Ерөө голын тойрогт багтана. Олборлолт явуулахаар төлөвлөж буй тусгай зөвшөөрөлтэй талбай нь нам уулсын уулын хээр, дэнжийн ургамалжилттай. Карбонаттай, хөнгөн шавранцар хүрэн хөрстэй дэнжийн хээр нь тусгай зөвшөөрөлтэй талбайн зүүн хойд талаар голын дэнж хэсэгт орших ба үетэн-алаг өвст бүлгэмдэл тархана.

Ус зүйн хувьд нь Туулын сав газар орших бөгөөд тус сав газар нь Монгол орны амьтаны аймгийн газарзүйн мужлалаар /Банников 1954/ Монгол дагуурын хээрийн тойрог , Хангайн тойрог хооронд оршдог тул амьтаны аймгийн бүрэлдхүүний хувьд нилээд өвөрмөу бөгөөд баялаг байжээ. Түүнчлэн энэ бүс нутаг нь байгалийн хувьд олон янзын амьдрах орчныг өөртөө агуулсан учир ихээхэн онцлогтой. Жишээлбэл энд хээрийн үндсэн амьтад, голын сав газрыг түшин амьдардаг амьтад зонхилон тархсан байна. Энэ бүс нутагт Монгол оронд хаягүй өргөн тархацтай, тоо толгойн хувьд ч элбэг тааралдах амьтдын төлөөлөгчид ч байдаг байжээ.

1.1. Уур амьсгал

Монгол орны уур амьсгал тус орны газарзүйн байршил онцлог, газрын гадаргын тогтоц, далайн төвшнөөс дээшхи өндөршлөөс шалтгаална. Өндөр уул, тэгш тал алаглан гадаргын байдал янз бүр байдаг явдал тухайн нутгийн уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын байдалд ихээхэн нөлөө үзүүлдэг юм. Хуурайдуу сэрүүн

зунтай, хүйтэн өвөлтэй.1-р сарын дундаж -17^{0}C,7-р сарын дундаж 15.5^{0}C, жилийн дундаж салхины хурд 5-10м/сек, жилийн хур тундасны нийлбэр 300- 400мм.



Хүснэгт 2. Агаарын дундаж температур

1.2. Хөрсний температур

2017 оны байдлаар хөрсний гадаргын температурын жилийн дундаж 0.9^0 С хүйтнээс 4.7^0 С дулаан ОЖД-тай харьцуулахад 0.5-1.7^0 С хүйтэн, бусад нутгаар 0.5-2.1^{0}С дулаан байсан байна .Хөрсний гадаргын үнэмлэхүй их температур 8-р сард 65.0^{0}С ба бусад нутгаар 51.0- 61.7^{0}С хүрч халсан байна. Хөрсний гадаргын үнэмлэхүй бага температур 11-р сард тус суманд 49.8^{0}С, бусад нутгаар 35- 44.0^{0}С хүрч хүйтэрсэн байна.

Хөрсний гадарга дээр өдөртөө 6-7 дугаар сард нийт нутгаар 60-68 градус, 8 дугаар сард ихэнх нутгаар 50-59 градус хүрч халсан байна.

1 дүгээр сард агаарын дундаж температур -17.0^{0}С, хамгийн их температур - 2.3^{0}С, хамгийн бага температур -29.4^{0}С байдаг бол 7 дугаар сард дундаж температур 19.4^{0}С, хамгийн их температур 32^{0}С, хамгийн бага температур 7.0^{0}С байдаг байна.
Бүрэгхангай сумын агаарын температурын сар бүрийн утгыг доорх хүснэгтэд үзүүлэв.

***Хүснэгт-3** Бүрэгхангай сумын темпратурын үзүүлэлт*

Сар/үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Сарын дундаж температур	-21.9	-17.9	-4.7	4	11.5	17.7	16.4	16.6	15.9	7.4	-8.7	-14.8
Хамгийн бага температур	-2.3	0.8	15.4	23.0	29.2	30.3	32.0	30.6	25.2	19.8	10.7	0.13
Хамгийн их температур	-29.4	-26.0	-20.9	-11.9	-5.0	2.6	6.9	3.9	-4.14	-11.8	-24.6	-27.2

1.3. Хур тунадас

Хур тунадас бол тус орны нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөлийг илэрхийлэгч чухал хүчин зүйлийн нэг юм. Тунадасны хуваарилалт газар нутгийн өндөр, ялангуяа чийг авч яваа агаарын урсгалын замд тохиолддог уулс яаж байрласнаас ихээхэн шалтгаалдаг. Бүрэнхангай сумын хувьд хур тунадасны 2017 оны жилийн хүйтний улирлын хур тунадасны дундаж хэмжээ 0.3-1.6 мм, дулааны улирлын хур тунадасны дулааны хэмжээ 2.5-5.3 мм байна. Нийт унах хур тунадасны ихэнх дулааны улиралд унадаг. Үүнээс харахад хур тунадас олон жилийн дундажаас бага байна.

1.4. Салхины горим

Агаарын даралт газрын гадарга дээр жигд бус хуваарилагдсанаас болж салхи буюу агаарын урсгал үүсч тэр нь дулаан хүйтэн, чийг, цас, бороо гэх мэт олон үзэгдлийг нэг газраас нөгөөд зөөж байдгийн хувьд агаарын даралт уур амьсгалын чухал элемент болдог. Салхины хамгийн их хурд 6-8 м/с, салхигүй өдрийн тоо 26, 15 м/с ба түүнээс

хүчтэй салхитай өдрийн тоо жилд 30, цасан шуургатай өдрийн тоо жилд 10- аас дээш, явган шуургатай өдрийн тоо жилд 10, шороон шуургатай өдрийн тоо жилд 30 байдаг байна. Салхины хамгийн их хурд 25 м/с хүрч байсан.

Салхины жилийн дундаж хурд 1.4-4.0 м/с, хамгийн их хурд 15-28 м/с буюу аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн байна. 2-9, 11-12 дугаар саруудад салхины их хурд Булган, Хутаг, Сэлэнгэ, Могод, Гурванбулаг, Орхон, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Бүрэгхангай сумдын нутгаар 20-28м/с бусад нутгаар 12-17м/с хүрч салхилсан байна. 4- р сард Бүрэгхангай суманд салхины хурд 28 м/с хүрчээ.

Хүснэгт.4 Бүрэгхангай сумын салхины үзүүлэлт

Сар Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Дундаж хурд, м/с	2.2	2.2	3.6	5,0	4.9	4.1	3.0	3.0	3.2	3.3	3.0	2.1
Хамгийн их хурд, м/с	15	18	22	20	17	22	20	17	22	19	14	18
Хамгийн бага хурд, м/с	1.2	1.9	2.4	3.1	3.1	3.1	2.0	1.9	2.3	2.6	1.5	1.4

1.5. Ус зүй

Ус зүйн сүлжээ их бөгөөд умард мөсөн далайн ай савд багтна. Гол сүлжээний нягтшил 0.10-0.15 км/км^2 байдаг. Гол мөрний нийлбэр урсац, газар доорх урсац, гадаргын урсац зэрэг нь 25мм-ээс дээш юм. Газар нутгийн чийгшил 200-250 мм, ууршилт200-250мм жилийн дулаан үеийн ууршилт 600-800 мм гол мөрний усны булингар 100 г/м^3 -аас дээш. Хатуу урсац жилд 3 м/км^2 дээш. Шар усны үерийн хамгийн их урсац хойд болон баруун нутгаар 10мм-ээс доош, зүүн болон өмнөд нутгийн багахан хэсгээр 250мм орчим. Борооны үерийн хамгийн их урсацын модуль 0.2-ээс дээш байдаг.

1.6. Хөрс

Бүрэгхэнгайн сумын нутагт орших ба төслийн талбайн хамрах бөгөөд Хөрс-Газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Хангайн их мужийн, *Хархүрэн, хүрэн хөрсний дэд бүст, Орхон -Шаамрын 1-р тойрогт* багтана. Тус нутагт ихэвчлэн уулын хар шороон хөрс, уулын хүрэн шороон хөрс зонхилж байдаг. Тухайн талбайд ерөнхийд уулын хар шороон хөрс, уулын хүрэн шороон хөрс тогтворжсон.

Монгол орны ботаник- газар зүйн мужлалаар Евразийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн Дорнод азийн дэд мужийн Орхон-Туул нам уулсын хээрийн газарзүйн тойрогт хамаарагддаг. Тус бүс нутаг ихэнх нутгийг Уулын хээрийн тойргийн ургамалжилттай. Байгалийн бүс бүслүүрийн хувьд (А.А.Юнатовынхаар) Дундаж өндөр ба нам уулсын хээрийн бүсэд багтана. Тус бүс нутагт үндсэндээ чулуулаг алаг өвс- ботуульт хэв шинжүүдийн ургамжилт ихэвчлэн зонхилдог. Ургамал газарзүйн мужлалаар Хангайн уулын ойт хээрийн провинц, Сэлэнгийн уулын ойт хээрийн тойргийн Бүрэгхангайн районд хамрагдана. Уулс нь налуу мөлгөр энгэртэй, хавтгайдуу оройтой гол төлөв арааараа шинэс хусан ойтой.

1.7. Амьтны аймаг

Ойн тархмал мэрэгчийн нэг хэрэм гол тэжээлээ дагаж хушин ойд хамгийн элбэг байна. Ойн зах унанги дархи, асга чулуутай хэсэгт жирх элбэг. Туурайтнаас бор гөрөөс, буга, зэрлэг гахай бүх ойт нугийн энгэрээр тархмал гэж болно. Аймгийн хамгийн хойд хэсэгт тайгын өндөр уулсын ар хажуугаар хүдэр нутаглана. Хантай, Бүрэн, Бүтээлийн нуруугаар хандгай, хүрэн баавгай, булга, нохой зээх нутаглана. Агнуураас шалтгаалан булга нэг үе их ховордсон ч өсч байна.Уулын өмнөд өвөр хажуу бэл голын хөндийн ой модгүй задгай газарт идээшсэн олон зүйл амьтан бий. Энд 16-17 зүйл мэрэгч тохилдохоос тарвага, урт сүүлт зурам, сибирийн алга даага, үлийн цагаан оготно, үлийн бор оготно бусдаас элбэг байна. *Шавьж идэштнээс*

дагуурын зараа, хонин малтаахай хоёр голын татам дэнж бэл хөндийгөөр тохилддог. Жижиг мэрэгч шувуу элбэг байгаа нь энд хярс, өмхий хүрэн зэрэг махан идэштэн олон байх нөгцөл болжээ. Хад чулуутай уулсаар мануул ховор биш үзэгдэнэ.

4. ТӨСЛӨӨС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Өгөөмөр шороон ордыг олборлох, төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болзошгүй сөрөг нөлөөллүүдийг ” байгаль орчны төлөв байдал, бүс нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, түүний эрчимшил зэргийг магадлан жагсаах аргаар тодорхойлж, болзошгүй нөлөөллийг тодрууллаа.

Хүснэгт.5 Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх усны нөөц	x				x		x	x		
Газрын доорх усны чанарын өөрчлөлт	x				x		x		x	
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x	x		
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x	x		
Зэрлэг амьтдын орон зай		x			x		x	x		
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x		x			x		x	
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	x				x		x	x		
Бэлчээрийн байдал	x				x	x			x	
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x	x		
Эрчим хүчний нөөц		x		x						x
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	x				x		x	x		
Урсгал усны хэрэгцээ		x		x					x	
Агаарын бохирдол		x		x					x	
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x	x			x				x
4. Байгалийн өнгө төрх, түүхи соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x		x	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх		x	x							x
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх		x	x							x
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх		x	x							x
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										

“ӨГӨӨМӨР” ОРДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2026

Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x				x	
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x				x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x		x	
Ажлын байр нэмэгдэх	x			x			x		x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x			x			x		x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x			x		x		x	
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x		x	
Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, ба грунтын усыг бохирдуулах	x				x	x			x	
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x			x		x	
Хүчтэй салхи, уруйн үер	x			x		x			x	
Дүн	21	10	4	8	9	5	18	8	17	5

“Өгөөмөр IV” нэртэй алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийг 6 бүлэг 31 асуулгыг магадлан жагсаан үргэлжлэх хугацаа, нөлөөллийн эрчимшил, буцалтгүй болон буцаж нөлөөлөх нөлөөлөл зэргийг тус тус тогтоон дээрх хүснэгтэд үзүүллээ.

Шууд бус нөлөөлөл. Нийт болзошгүй нөлөөллийн 21 шууд, 10 нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Газрын доорх усны өөрчлөлт, түүний нөөцийн хомсдол, хөрсний элэгдэл эвдрэл, ургамлан нөмрөгийн өөрчлөлт бэлчээрийн хомсдол, байгалийн үзэсгэлэнт төрхийн өөрчлөлт,зэргүүдэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Харин орон нутгийн орлого нэмэгдэх, ядуурлыг бууруулах, ажлын байр шинээр бий болох зэрэг нөлөөллүүдэд эерэгээр нөлөөлөхөөр байна.

Нөлөөллийн хугацаа. 19 нөлөөлөл нь урт хугацаагаар,8 нь богино хугацааны нөлөөлөлд хамаарагдаж байна.

Буцаж нөлөөлөх. Ахуйн болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон хөрс, гүний усыг бохирдуулах улмаар хүн, мал, амьтны эрүүл мэндэд шууд ба шууд бусаар эргэж нөлөөлөх, ахуйн хаягдлыг тухай бүр устгаагүй болон ариутгаагүйгээс болж хаягдлын цэгт ялаа шавж үржих зэргээр таагүй нөлөөлөх магадлалтай.

5.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ,ХАМРАХ ХҮРЭЭ

Уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьдаг.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгосон. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаж байна.

2026 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараахи гол зорилтуудыг тавьж ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

- Тухайн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь үндсэн үйл ажиллагаа эхлэх хүртэл хугацаанд өмнөх жил үүсгэсэн гадаад овоолго тээвэрлэх, нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх зорилт бүхий төлөвлөгөө бөгөөд нөхөн сэргээлтийн ажлын үр дүн бүтээмж нэмэгдүүлэх
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг сайжруулж, түүнд нутгийн иргэдийг оролцоог хангах .
- Нөхөн сэргээлтийн ажлын үр дүн бүтээмжийг сайжруулан техникийн нөхөн сэргээлтийг холбогдох стандартад нийцүүлэн чанартай хийж гүйцэтгэх.
- Орон нутгийн иргэн албан хаагчидад байгаль орчны чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлыг танилцуулж нээлттэй хамтын ажилгааг хөгжүүлэх

Эрх зүйн үндэслэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагварыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А-618тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”, зэргийг удирдлага болгов.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтоо биелүүлэхийн тулд Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг барьж ажиллана.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй:

Уг төслийн хүрээнд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шимт хөрсний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах үүднээс биологийн нөхөн сэргээлт хийх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ хог хаягдлын менежмент удирдлага зохион байгуулалтын зардал, орчны хяналт шинжилгээ хийх зэрэг үндсэн хэсгүүд дэх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлыг тооцсон болно. Мөн байгаль хамгаалах зарим нэг урьдчилан тооцоолох боломжгүй зардлыг үйл ажиллагааны болон үйлдвэрлэлийн зардалд тухай бүр нь тусгаж ажиллана.

Хүснэгт 6. 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Хөтөлбөр	Төсөв сая.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6.0
2	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	-
3	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	12.5
4	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	0.5
5	Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр	9.0
6	Олон нийт тайлагнах хөтөлбөр	0.5
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3.5
	Нийт	**30.0**

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчин буюу агаарын чанар, газрын гадарга болон хэвлий, усан орчин, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзэн тухайн төслөөс үүсэх гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлсны үндсэн дээр сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулах талаар ерөнхий төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээг хугацаа болон зардал мөнгөтэй нь доорх хүснэгтээр үзүүллээ.

Хүснэгт .7 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг сая/т	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль журам стандарт
АГААР МАНДАЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ , БУУРУУЛАХ, БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
1	Тоосжилт, агаарын бохирдолын эх үүсвэрүүд Хөрсний чийг бага салхи ихтэй үед агаар дахь тоосны хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх	1.1 Дотоод тээвэрлэлтээс үүсэх тоосжилтийг дарах зорилгоор усалгаа хийх /Зуны улиралд/	Уурхайн доторх болон гадна зам талбай	ҮАЗ	Ажиллах хугацаанд	Агаарын тухай -Байгаль орчныг хамгаалах тухай -Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. MNS 4585:2016 Стандарт
		1.2 Төслийн үйл ажиллагаанп ашиглах, машин техникүүдийг улсын үзлэгт тухай бүрд нь хамруулах /Агаарын бохирдолын төлбөр төлөх/	Тээвэрлэлт болон төсөлд ашиглэх бүх техник	ҮАЗ	Ажиллах хугацаанд	
		1.3 Тоосжилт бууруулах, тоос барих технологи, сайн туршлагийг судлах	Олборлолтын талбайн хэмжээнд	1600.0	Ажиллах хугацаанд	
		1.4 Технологийн зам дагуух тэмдэг тэмдэглэгээг засаж сайжруулах, нэмэлт тэмдэг байршуулах.	Ажиллах нийт хугацаанд	ХАБ-ын зардалд	Төсөл хэрэгжих хугацаанд	
		1.5 Тээвэрэлт хийх шороон замд тээврийн жолооч нарт хурдны хязгаарлалт тавих	Ажиллах нийт хугацаанд		Ажиллах хугацаанд	
Дүн				*Нийт-1600,0*		
2. ХӨРС ГАЗРЫН ГАДАРГАД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ						

2	Хөрс хуулалт хийх, баяжуулах үйл ажиллагааны үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар алдагдах	2.1 Уулын ажлын төлөвлөгөөгөөр карьерын тэлэлт хийгдэх хөрсний үржил шимт чанараас хамааран 30-50см орчим зузаан хуулж овоолго үүсгэн, хэлбэржүүлэн хадгалах.	Уурхайн тэлэлтэнд өртөх бүх талбай	ҮАЗ	Ажиллах хугацаанд	Үржил шимт хөрсийг хуулах, хадгалах стандарт MNS 5916:2023
	Бензин тос, дизель шатах тослох, материал зэргийн асгаралт ахуйн хог хаягдалаас хөрсний бохирдол үүсэх	2.2 Тээврийн хэрэгслийн батлагдсан маршрутын дагуу явах, тэмдэг тэмдэглэгээг байршуулах.	Уурхай,кемп	ҮАЗ	Төслийн үе-ний хүрээнд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, Байгаль орчныг хамгаалах турай хуулиуд
	Хүнд машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарах, хөрсний шороо суларч элэгдэл эвдрэлт өртөх	2.3 Төлөвлөлтөөс гадуурх талбайд нүх ухах, олон салаа зам гаргахгүй байх, инженер техникийн ажилчдад сургалт орох.	Бүх ажилчид	1000.0	4,10 сард	Байгаль орчныг хамгаалх тухай хууль, хөрсний тухай хууль
Дүн				1000.0		
3. УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ						
3	Усан сан бүхий газар, хамгаалалтын бүс, унд , ахуйн худгийн эрүүл ахуйн бүс хог хаягдалаар бохирдох, уурхайн үйл ажиллагаанд өртөх.	3.1 Жил бүр ус ашиглах дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаар гаргуулж ажиллах.	Уурхайн хэмжээнд	1800	4 сард	MNS0900:2018- Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:1992 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ;
	Гадаргын болон гүний усан орчинд урсацын горим алдагдаж болзошгүй.	3.2 Усан хангамжийн худгууд дээр усны чанарын шинжилгээг хийх, хяналт тавьж ажиллах.	ОХШХ-т багтсан	ҮАЗ	Жилд 1-2удаа	MNS0900:1992 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ; MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага;
Дүн				1800		

УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ **ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**						
4	Ногоон байгууламж	4.1 Өмнө жилүүдэд суулгасан модны суулгацын усалгаа, арчилгааг гүйцэтгэх. /Усалгааны хуваарь гаргах/ 4.3 Хайлаас үр-2кг Бургас мөчрөөр-2000ш бэлтгэж стандартын дагуу хадгалах.	Тарилт хийсэн газруудад	ҮАЗ-д тусгагдсан	Төлөвлөгөөний дагуу	Ургамал хамгааллын тухай -Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай
	Ургамлан нөмрөг хамгаалах	4.2 Уурхайн дотоод, гадаад тээвэрлэлтийн маршрутыг зөв гаргах. /Ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэх талбайг хамгийн бага хэмжээнд төлөвлөх/.	Төслийн талбайн хэмжээнд		11 сар хүртлэх	
Дүн				-		
5. АМЬТАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ						
5	Төслийн үйл ажиллагаанд том машин техникийн нөлөөгөр зэрлэг ан амьтадын тоо толгой буурах, үргэж дайжих сөрөг нөлөөтэй	5.1 Төслийн талбайд боломжтой газруудад хаягдал мод ашиглан шувууны үүр хийж байршуулах.	Уурхайн ажилчид БОМ	1200	4,10 сард	Байгаль орчныг хамгаалах тухай хууль -Амьтны тухай хууль
		5.2 Төслийн явцад тээврийн жолоочдыг зэрлэг ан амьтныг цочоож үргээхгүй байх, хууль бусаар ан ав хийлгэхгүй байх талаар сургалт орж, хяналт тавих		400.0		
Нийт		***15 ажил,арга хэмжээ***		6000		

7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Олборлосон газраа нөхөн сэргээж унаган төрхийг нь эргүүлэн тогтоож хонхор хотгорыг нь тэгшилж үүсмэл овгор гүдгэр овоолгыг тэгшилж, уурхай байгуулахаас өмнөх хэлбэрт оруулах нь байгаль орчныг хамгааллын үндсэн шаардлага юм.

Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 12 сарын 29-ний өдөр баталсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачилал” -ын дагуу хийж гүйцэтгэхээр төлөвлөв.

Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө зардал, аргачлал

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт өртөг (сая.төг)	Баримтлах стандарт, аргачлал
Техникийн нөхөн сэргээлт	Дүүргэлт	8.0 га талбайд дүүргэлт гүйцэтгэх	УАЗ	MNS-5917-2008,
Биологийн нөхөн сэргээлт	Бэлчээрийн олон наст тарих	3.5 га	13.0	MNS-5918-2023,

“Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт.” MNS 5914-2008; ”Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал” /MNS 5915-2008/; ”Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт /MNS 5916-2008/; ”Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5917-2008/ стандартын дагуу төлөвлөгөөг гүйцэтгэх болно.

8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн БОННҮ-ний тайланд тусгаснаар “Ордтой холбоотойгоор бэлчээрийн газарт үзүүлэх үлдэгдэл нөлөөллийн асуудлыг авч үзэж, шийдвэрлэхийн тулд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаагаар бэлчээрийн ургамлын бүлгэмдлүүдийн биологийн олон янз байдлын үнэ цэнийг нөхөн хамгаалвал зохино“ гэж тодорхойлсон байдаг тул “Сайжруулалт ба нөхөн сэргээлт”-ийн хувилбарыг сонгон авсан.

Хүснэгт.9 Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал Сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж
“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд	Төслийн талбайд мод тарих	2га			
	Үржүүлгийн зорилгоор Улиас, Бургас мөчрөөр тарилт хийх	ш	15000ш	5000	5-6сар
Орон нутгийн тусгай хэрэгцээний газарт нөхөн сэргэгдээгүй орхигдсон талбайг нөхөн сэргээх	Булган аймгийн БО-ны газартай зөвшилцсөний дагуу	1га			
			Нийт дүн		9000.0

9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус арга хэмжээ нь төсөлд хамааралгүй болно.

10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус арга хэмжээ нь төсөлд хамааралгүй болно. Бид үйл ажиллагааны явцад түүх соѐлын өвийг хамгаалах арга хэмжээнд нэн тэргүүний ач холбогдол өгч холбогдох арга хэмжээний хүрээнд арга хэмжээ авч ажиллах болно.

11. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул,гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

“ӨГӨӨМӨР” ОРДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2026

Хүснэгт 10.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг сая/т	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль журам стандарт
	1	**2**	**3**	**4**	**5**	**6**
1	**Аадар бороо, үер**	10.1 Үерт өртөж болзошгүй хэсэгт шар усны болон гэнэтийн аадар бороонооос үүсэх үерийн аюулаас сэргийлэхийн тулд далан хаалт суваг шуудуу ухах.	Карьер, кемп	УАЗ	Ажиллах хугацаанд	Гамшигаас хамгаалах тухай хууль
		10.2 Хажуугийн урсацаар хөрс эвдрэх, уруйн идэгдэлд өртөж болзошгүй газруудад мөр жим гаргахгүй байх талаас анхаарч, жалганы ойролцоо хог хаягдлын цэг, шатах тослох материалын агуулах	Ажиллах нийт хугацаанд	Зардал шаардахгүй	Ажиллах хугацаанд	Гамшигаас хамгаалах тухай хууль Хог хаягдлын тухай хууль
2	**Аянга, цахилгаан**	10.3 Цахилгаан цэнэгтэй орчноос аль болох зайдуу байх, цахилгаан цэнэгтэй тоног төхөөрөмжүүдийг унтраах, аянга цахилгаантай үед хэмжилт хийх болон цахилгаан цэнэг үүсгэх багаж төхөөрөмжтэй ажиллахаас зайлсхийх.	Ажиллах нийт хугацаанд	Зардал шаардахгүй	Ажиллах хугацаанд	
3	**Хүчтэй салхи, шуурга**	10.4 Хүчтэй салхины цаг агаарын шинэчилсэн мэдээллийг тогтмол сонсож уурхайн шуурхай хуралдаан дээр мэдээлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх.	Ажиллах нийт хугацаанд	Зардал шаардахгүй	Ажиллах хугацаанд	Гамшигаас хамгаалах тухай хууль Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
		10.5 Үзэгдэх орчин хязгаарлагдмал нөхцөл үүссэн үед Уулын ажлыг түр зогсоох арга хэмжээг авах	Ажиллах нийт хугацаанд	Зардал шаардахгүй	Ажиллах хугацаанд	

12. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 онд “Хос Хас” ХХК-ийн Өгөөмөр ордын орчимд байрлах хотхонд байрлан ажиллах бөгөөд ахуйн хог хаягдал , аюултай хог хаягдалын нөлөөлөл бууруулах арга хэмжээний чиглэлээр дараахи ажлуудыг гүйцэтгэнэ.

“Хог хаягдлын тухай хууль”-ийн шинэчлэгдсэн найруулгын дагуу боловсруулж ажиллана.Хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлж, хэвшүүлэх эхний алхам нь ангилан ялгалт, дахин ашиглалт юм

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан ажиллах бөгөөд дараах зарчмыг баримтална.

- “Хог хаягдлын тухай хууль’’-ийн шинэчлэгдсэн найруулгын дагуу Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, мөрдлөг болгон ажиллана.
- Хог хаягдлын менежментийн хүрээнд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас болон 2019 оны 5 сарын 07-ны өдрийн “Хог хаягдлын менежмент” Үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийг дагаж мөрдөнө.
- ХХМТ-г хэрэгжүүлэх журам болон бусад холбогдох бичиг баримтуудын биелэлтэнд хяналт тавина.

15.1. Нийтийн эдэлбэр газар байршуулах хогийн сав дараах шаардлагыг хангасан байна.

15.1.1 Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн

15.1.2 Галд тэсвэртэй материалаар хийгдсэн

.1.3 Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус, хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.

Зураг.Хог хаягдлыг ангилан ялгалтын менежментийн дараалал

Хүснэгт.11 ***Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө***

Хог хаягдлын ангилал	**Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ**	**Арга хэмжээний цар, хэмжээ**	**Нэгжийн өртөг сая/т**	**Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж**	**Баримтлах хууль журам стандарт**
Ахуйн	12.1Хог хаягдлын гэрээг орон нутагтай байгуулж, төлбөрийг гэрээний дагуу төлөх	Бүрэгхангай сум	YAЗ	4-12сар хүртлэх	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль
	12.2 Хог хаягдлын бүртгэл хөтлөх	Бүх хэсэг нэгж	YAЗ	Ажиллах хугацаанд	
	12.3 Ахуйн хог хаягдлаас дахин боловсруулах хог хаягдлыг “Дахивар нийлүүлэх газарт тушаах”	Кемп менежер, БОМ	YAЗ	Ажиллах хугацаанд	
	12.4 Дулааны улиралд хогийн сав, гал тогоо, ариун цэврийн байгууламжинд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх.	Кемп менежер	YAЗ	Ажиллах хугацаанд	
	12.5 Орчны хог хаягдалд хяналт тавьж, Нийтийн цэвэрлэгээний хуваарийн дагуу орчны цэвэрлэгээ хийх.	Бүх хэсэг нэгж,БОМ	YAЗ	Ажиллах хугацаанд	
Аюултай хог хаягдал	12.6 Аюултай хог хаягдлыг ангилан бүртгэлжүүлж, тогтсон цэгт хураах	ЗМХ БОМ	YAЗ	Ажиллах хугацаанд	Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Хог хаягдлын тухай хууль
	12.7 Хог хаягдлын ангилан ялгалтын бункер хийж байршуулах	ЗМХ, КЕМП	YAЗ	Ажиллах хугацаанд	
	12.8 Хаягдал тос масло хураах цэгт-хадгалсан тоснуудыг дахин боловсруулах үйлдвэрт гэрээ хийж нийлүүлэх. /Хяналт тавьж ажиллах/	ЗМХ БОМ	YAЗ	Ажиллах хугацаанд	
Бусад	12. 9 Шинээр барьсан хог хаягдлын цэгт-хаягжуулалт хийх, хяналт тавьж ажиллах	БОМ, кемп менежер	YAЗ	Ажиллах хугацаанд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль
	12.10 Хүрээлэн буй орчны бохирдол,түүнээс урьдчилан сэргийлэх тухай сургалт орох /Нийт ажилчид	БОМ, нийт ажилчид			

13. 2026 ОН БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх бүхий л сөрөг нөлөөллийн хамгийн бага байхаар тооцож байгаль орчны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөтэй ажиллана.

***Хүснэгт 12**. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2026 он	Зардал, төг	Хариуцагч
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Төслийн хугацаанд	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн дарга
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.	5сард	-	ГУУХ захирал
3	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Бүрэгхангай сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	11 сард	400	ГУУХ захирал
4	Төслийн үйл ажиллагаанд орон нутгийн ажил горилогч иргэдийг уурхайн сул орон тоон ажлын байраар хангах	4 сар	ҮАЗ	ГУУХ захирал
5	Ажилчдын хүнсэнд хэрэглэх мах, сүүн бүтээгдэхүүнийг орон нутгийн малчидаас худалдан авах боломж бүрдүүлэн хамьтрн ажиллах	6 сар	ҮАЗ	ГУУХ захирал
6	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд цаашид хийх ажлыг төлөвлөх талуудын уулзалтыг зохион байгуулж авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах	5 сард	1000	ГУУХ захирал
Нийт зардал			**1400.0**	

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчин, оршин суугчдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийн бууруулах, хяналт тавих зэрэг арга хэмжээ орох тул тухайн онд ямар арга хэмжээ төлөвлөж ажиллахыг орон нутгийн оршин суугчид, оролцогч талуудын оролцоо зайлшгүй байх ёстой зүйл юм.

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрт оршин суугчдад БОМТ-ний төлөвлөлт хэрэгжилтийн талаар, үйлдвэрлэлийн орчмын эрсдэлийн биологийн нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл өгч ажиллана.

Хүснэгт-13 *БОМТ-г хэрэгжилтийг тайлагнах хуваарь*

БОМТ хэрэгжилтийг тайлагнах,хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээ эр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Төслийн талбайн орчимд	Танилцуулга санал авах	Биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөлт тайлан	Төслийн хугацаанд	БОХ арга хэмжээний тайлан ирэх оны төлөвлөгөөний төсөл	Талбайн орчимд
Захирамжаар томиологдсон комиссын гишүүд	Комиссын шалгалт, хурал	Тайлангийн хэрэгжилтийн шалгалт	12-р сарын 1 дотор		Уурхай
БОАЖЯ	Албан бичиг	Тайлан Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 31		Улаанбаатар хот

15. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчны менежментийн төлөвлөөгөөний салшгүй нэг хэсэг бөгөөд төслийн үйл ажиллагаа байгаль орчин, нутгийн иргэд, ажиллагсадын амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, хүрээлэн буй орчны бүрдлүүд бүр дээр холбогдох итгэмжлэгдсэн лабораториудаар хяналт шинжилгээг хийлгэж стандартын шаардлагыг хангаж байгаа эсэх талаар анализ хийж зөрчил илэрсэн тохиолдолд бууруулах, арилгах арга хэмжээ авах шаардлагатай.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн

иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамжийг тодорхойлон оруулна. Мөн уг ажлын хэмжээг хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зардал, баримтлах стандарт, аргазүй, аргачлалыг тусгана.

Орчны хяналт шинжилгээний ажлыг жил бүрийн байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланд оруулж байгаль орчны асуудал эрхэлсэн орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана. Мөн байгууллагын дотоодын хяналтыг хэрэгжүүлэх, төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг тухай бүр хянах, цаг алдалгүй хариу арга хэмжээ авах зорилгоор байгаль орчны асуудал хариуцсан ажилтан улирал тутам хяналт шинжилгээний дүн мэдээгээр тайлан бэлтгэж, зохих удирдлагадаа тайлагнана. Бид тус онд хөтөлбөрийн хүрээнд Булган аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газрын дэргэдэх лабраторитой хамтран ажиллах гэрээ байгуулан шинжилгээ гүйцэтгүүлэнэ.

Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөр шинжилгээ хийх төсөв төлөвлөлт

№	Шинжилгээ хийлгэх үзүүлэлүүд	Хяналт шинжилгээ хийх цэгийн байршил	Давтамж	Стандарт	Шинжилгээ хийлгэх лаборатори	Төсөв сая.төг
	Агаарын хяналт шинжилгээ					
1	NO2, CO, SO2, CH4-ийн агууламж, Тоосонцорын / PM10, PM2.5/ агууламж Дуу шуугианы түвшин	Ил уурхай-1 Баяжуулах үйлдвэрээс салхины доор-1 Хотхон	5дугаар сар	MNS 4585:2007 Дуу чимээ	Булган аймгийн УЦАУОШГазрын БО-ны лаборатори,	1.7
	Усны хяналт шинжилгээ					
2	Ерөнхий хими Бактерлиоги	Туул гол орчимд -1 Ундны худаг-1	5дугаар сар	MNS 0900:2005	Булган аймгийн УЦАУОШГазрын БО-ны лаборатори,	0.5
	Хөрсний хяналт шинжилгээ					
4	Ялзмаг, механик бүрэлдэхүүн, давсны агууламж, хөдөлгөөнт элемент Хүнд металлын (Pb, Cd, Zn, As, Sr, Ni) агууламж	Ил уурхай-2 Хотхон -1 ШТС-1	5дугаар сар	MNS 5850:2008	Булган аймгийн УЦАУОШГазрын БО-ны лаборатори,	0.8
6	**Нийт**				**3.5**	

16. ДҮГНЭЛТ

“Хос Хас” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэнд нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьж ажиллах бөгөөд үйл ажиллагааны явцад нөхөн сэргээлт болон хог хаягдалын менежементийг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллахад гол зорилт болгон ажиллана .

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль орчин нөхөн сэргээх зардалд 30,0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг Булган аймгийн Цаг уур орчны шинжилгээний газрын дэргэдэх лаборатори, Нарт шуун хөрсний лабораторуудаар гүйцэтгэхээр төлөвлөлөө.

Бид тус байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн талбайн ТЭЗҮ болон БОННҮ-ний ажлын төлөвлөгөөнд тулгуурлан Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн А-618 тоот тушаалын дагуу боловсруулав.

“ӨГӨӨМӨР” ОРДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2026

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Төслийн Техник эдийн засгийн үндэслэл
2. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээний тайлан
3. БОМТ боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
4. Байгаль орчин ногоон хөгжлийн яамны вэб сайт –www.met.gov.mn
5. Ашигт малтмал уул уурхайн вэб сайт https://www.mrpam.gov.mn/
6. Эрхзүйн мэдээллийн сайт – www.legalinfo.mn
7. Уул уурхайн ашигт малтмал, ТЭЗҮ нэгдсэн журмын

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

Хавсралт 1. Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ
Хавсралт 2. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ,
Хавсралт 3. 2025 оны Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний баталгаажсан нүүр
Хавсралт 4. 2025 оны Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний Байгаль орчинтой холбоотой маягтууд
Хавсралт 5. Байгаль орчныг хамгаалах баталгааны мөнгөн хөрөнгө байршуулсан баримт
Хавсралт 6. Нөхөн сэргээлт, ОХШХ-ийн цэг, бусад мэдээлэл агуулсан зураг